

Po splnění povinné školní docházky, mohou žáci pokračovat ve vzdělávání na střední škole.

Přijímací řízení se liší podle typu oboru. Na většinu oborů je nutné podat přihlášky v 1. kole v **únoru**. Je možné podat až 3 přihlášky. Uchazeči přitom školám přiřazují prioritu podle toho, v jakém pořadí školy preferují.

Obory, na nichž je součástí přijímacího řízení **talentová zkouška** (umělecké, sportovní), mají termín podání přihlášek v 1. kole do **30. 11.** (max. 2 přihlášky).

Na SŠ s **obory ukončenými maturitní zkouškou** je třeba **absolvovat jednotné přijímací zkoušky (JPZ) z matematiky a z českého jazyka a literatury**. Každý uchazeč bude konat JPZ 2x. Započítává se jen lepší dosažený výsledek z obou termínů.

Některé školy mohou mít vypsané také tzv. **školní přijímací zkoušky** např. z cizího jazyka, tělesné zdatnosti, manuální zručnosti apod. Jejich termíny jsou také zveřejněny v kritériích přijímacího řízení na konkrétní školu. Přesný termín školní zkoušky obdrží uchazeč v pozvánce k přijímacímu řízení.

DŮLEŽITÉ TERMÍNY:

- ✳️ zveřejnění **kritérií přijímacího řízení** na webových stránkách SŠ: do **31. 1.** (podmínky pro přijetí do jednotlivých oborů středního vzdělávání např. potvrzení od lékaře)
- ✳️ **termíny podání přihlášek – 1. kolo:**
 - do **30. 11.** - přihlášky na **obory s talentovou zkouškou** (tanec, drama, hudební obory, výtvarné obory, sportovní gymnázia)
 - do **20. 2.** - podání přihlášek na ostatní SŠ
- ✳️ **jednotná přijímací zkouška** na 4leté maturitní obory (ukončené maturitní zkouškou) – jednotná přijímací zkouška z českého jazyka a matematiky - pracovní dny od 12. 4 do 28. 4.

PŘIHLÁŠKY

K přihlášení slouží především oficiální webový portál: www.prihlaskynastredni.cz. Přihlášky je možné podat těmito způsoby:

- ✓ Elektronicky (s ověřenou elektronickou identitou – Mobilní klíč eGovernmentu nebo Bankovní identita).
- ✓ Podáním výpisu vytištěného z online systému.
- ✓ Podáním vyplněné papírové přihlášky s přílohami.

Vysvědčení se nově dokládá formou přílohy - stačí scan nebo prostá kopie.

- ✳️ **1. kolo** – je možné podat **3 přihlášky** (plus další dvě na obory s talentovými zkouškami)
- ✳️ **2. kolo** – **3 přihlášky** – podané **20.-24.5.** (pro rok 2024); ve 2. kole je také možné navíc podat až 2 další přihlášky na obory s talentovou zkouškou
- ! **Pozor** – na maturitní obory (s JPZ) se v 2. kole mohou hlásit pouze uchazeči, kteří se na maturitní obory hlásili už v 1. kole a konali JPZ
- ✳️ **3. a další kola** – počet přihlášek není omezen

ÚPRAVY PŘIJÍMACÍHO ŘÍZENÍ

Uchazeči, kteří ukončili předchozí vzdělání mimo Českou republiku, mají právo podat žádost o **prominutí přijímací zkoušky z českého jazyka** (týká se to jednotné přijímací zkoušky z českého jazyka a literatury). Škola v takovém případě **ověří znalost českého jazyka pohovorem**.

Uchazeči s odlišným mateřským jazykem mají nárok na další úpravu podmínek přijímacího řízení, pokud k přihlášce na SŠ doloží písemné **doporučení školského poradenského zařízení (ŠPZ) pro uzpůsobení přijímacích zkoušek**. To může obnášet prodloužení času na vypracování písemné zkoušky a/nebo využití kompenzačních pomůcek (např. překladový slovník). To se týká i případné školní přijímací zkoušky.

- ! Uchazeči z Ukrajiny s dočasnou ochranou mají na čas navíc (25%) a překladový slovník nárok i bez doporučení ŠPZ.
- ! U jednotné přijímací zkoušky z matematiky mohou místo toho požádat o možnost skládat písemný test v ukrajinském jazyce.

VÝSLEDKY PŘIJÍMACÍHO ŘÍZENÍ A PŘIJETÍ KE VZDĚLÁVÁNÍ NA SŠ

CERMAT na základě výsledků a pořadí uchazečů, které mu zašlou školy, porovná výsledky všech uchazečů na všech školách a umístí je podle toho do jednotlivých škol. Uchazeč, který by se dostal na více škol, bude automaticky přijat ke studiu na té z nich, které přiřadil nejvyšší prioritu.

Všechny výsledky budou zveřejněny 15.5. 2024 v elektronickém systému a na webových stránkách škol.

NEPŘIJETÍ KE VZDĚLÁVÁNÍ NA SŠ

Uchazeči, kteří se nedostali na SŠ v 1. kole mohou **podávat přihlášky v 2. kole a dalších kolech následujících**.

Jestliže nebyl uchazeč přijat, může v případě pochybnosti o regulérním průběhu zkoušek podat **odvolání do 3 pracovních dnů** ode dne zveřejnění výsledků.

Pokud školy zjistí, že mají po 1. kole ještě volná místa, mohou vyhlásit druhé kolo přijímacího řízení (případně i další kola) na obory, kde nebyla naplněna kapacita. Kritéria pro další kola se mohou lišit.

UŽITEČNÉ ODKAZY:

- 🔗 <http://www.inkluzivniskola.cz/prijimaci-rizeni-na-ss>
- 🔗 <https://prijimacky.cermat.cz/>

- ▶ [Školská poradenská zařízení \(ŠPZ\)](#)

Ерөнхий боловсролын сургуулийг хуулийн дагуу төгссөний дараагаар сурагч цааш үргэлжлүүлэн дунд сургуульд суралцах боломжтой байна.

Элсэлтийн нөхцөл нь мэргэшлийн ангийн төрлөөс хамааран өөр өөр байдаг. Ихэнх мэргэшлийн ангийн хувьд өргөдлийг **2-р сардаа багтан** 1-р шатанд өгөх ёстой байдаг. 3 хүртэлх өргөдөл гаргах боломжтой. Үүний зэрэгцээ өргөдөл гаргагчид сургуулиудыг сонгосон дарааллаар нь сургуулиудад давуу эрх олгодог болно.

Авьяас чадварын шалгалт (урлаг, спорт) нь элсэлтийн нэг хэсэг болох мэргэшлийн сургуулийн элсэлтийг 1-р шатанд **11-р сарын 30-ны дотор өгнө** (хамгийн ихдээ 2 сургуульд өргөдөл гаргаж болно).

Дунд сургуулийг **SŠ дипломтой төгсөх ангид** элсэлт өгөхийг хүсвэл зайлшгүй **элсэлтийн нэгдсэн шалгалтыг (JPZ) чех хэл, уран зохиол, математик** гэх хичээлүүдээр шалгалт өгөх ёстой. Өргөдөл гаргагч бүр JPZ-г хоёр удаа өгөх бөгөөд зөвхөн хоёр шалгалтын илүү сайн үр дүнд хүрсэн дүнг тооцно. Зарим сургуулиуд **сургуулийн элсэлтийн шалгалт** авдаг байгаа, үүнд гадаад хэл, бие бялдрын сорил, гарын ур чадвар гэх мэт. Тэдний огноог мөн тухайн сургуулийн элсэлтийн шалгуурт нийтэлдэг. Өргөдөл гаргагч нь сургуулийн элсэлтийн журмын тухай урилгад тухайн шалгалтын мэдээллийг хүлээн авна.

DŮLEŽITÉ TERMÍNY:

- ✳ элсэлтийн шалгуурыг дунд сургуулийн вэбсайтад нийтлэх огноо: **1 сарын 31** (дунд боловсролын бие даасан чиглэлээр элсэх нөхцөл, жиш.:эмчийн тодорхойлолт)
- ✳ өргөдөл гаргах эцсийн хугацаа – 1. шат:
 - **11 сарын 30-г хүртэл** - авьяас чадварын сорил шалгалт өгөх өргөдөл (бүжиг, жүжиг, хөгжим, урлагийн төрөл болон спорт, гимнастик)
 - **2 сарын 20 хүртэл** – бусад дунд сургуульд өргөдөл гаргах
- ✳ дипломтой төгсөх 4 жилийн элсэлтийн нэгдсэн шалгалт (дипломын шалгалтаар төгсөх шалгууртай) – чех хэл, математикийн элсэлтийн нэгдсэн шалгалт - 4 сарын 12-с 4 сарын 28 хүртэлх ажлын өдрүүд

ӨРГӨДӨЛ

Элсэлтийн албан ёсны вэб порталыг ашиглана: www.prihlaskynastredni.cz. Өргөдлийг дараах хэлбэрээр гаргаж болно:

- ✓ Цахимаар (баталгаажуулсан цахим үнэмлэх – Mobilní klíč eGovernmentu аль эсвэл Bankovní identita).
- ✓ Онлайн системээс татан авч хэвлэсэн бөглөсөн мэдэгдлийг хүргүүлсэнээр.
- ✓ Цаасан өргөдлийг хавсралтын хамт хүргүүлсэнээр.

Төгсөлтийн хичээлийн дүнг шинээр хавсралт маягаар илгээж болно - скан эсвэл энгийн хуулбар хангалттай.

- ✳ **1. шат – 3 өргөдөл** гаргах боломжтой (нэмэх нь хоёр авьяас чадварын шалгалттай мэргэшлийн ангид)
- ✳ **2. шат – 3 өргөдөл – 5 сарын 20.-24.** хооронд гаргасан байх (2024 оны хувьд); 2-р шатанд авьяас чадварын шалгалттай мэргэшлийн ангид 2 хүртэлх нэмэлт өргөдөл гаргах боломжтой байна.
- ! Анхаар – дипломтой төгсөх ангид (JPZ-тай) 2. шатны өргөдлийг зөвхөн 1. шатанд дипломтой төгсөх ангид JPZ өгсөн сурагч өгч болно.
- ✳ **3. болон бусад шат** – өргөдлийн тоо хязгаарлагдахгүй

ЭЛСЭЛТИЙН ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД

БНЧУ-аас өөр улсад ерөнхий боловсролын суруулиа төгссөн өргөдөл гаргагчид **чех хэлний элсэлтийн шалгалтаас чөлөөлөгдөх хүсэлт** гаргах эрхтэй байна (энэ нь чех хэл болон уран зохиолын элсэлтийн нэгдсэн шалгалтыг хэлнэ). Ийм тохиолдолд тухайн сургууль **чех хэлний мэдлэгийг ярилцлагаар шалгана**.

Төрлөх хэл нь өөр эх хэлтэй өргөдөл гаргагчид элсэлтийн журмын нөхцлийг мөн өөрчлөх эрхтэй байна. Үүнд, дунд сургуульд элсэх өргөдөлд **сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагаас (ŠPZ) элсэлтийн шалгалтыг тохируулах талаар бичгээр өгсөн зөвлөмжийг хавсаргасан бол**. Энэ нь бичгийн шалгалтанд бэлтгэх хугацааг уртасгах эсвэл/болон нөхөн олговрын хэрэгслийг ашиглахтай холбоотой байж болно (жиш. орчуулгын толь бичиг). Энэ нь мөн сургуулийн элсэлтийн шалгалтад хамаатай байж болно.

! Түр хамгаалалттай Украин өргөдөл гаргагчид ŠPZ-ын зөвлөмж шаардлаггүй бөгөөд тэдэнд нэмэлт цаг (25%), орчуулгын толь бичиг авах эрхтэй байна.

! Математикийн элсэлтийн нэгдсэн шалгалтын хувьд тэд Украин хэл дээр бичгээр шалгалт өгөх сонголтыг хүсч болно.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ДҮН БОЛОН ДУНД СУРГУУЛЬД ЭЛСЭЖ ОРСОН ТУХАЙ

CERMAT нь сургууль тус бүрээс хүргэгдэн ирсэн өргөдөл гаргагчийн шалгалтын дүнг боловсруулаж жагсаалт гарган бүх сургуулийн өргөдөл гаргагчийн хариуг сургуулиудад танилцуулдаг. Нэгээс олон сургуульд элсэх өргөдөл гаргагч нь амжилттай олон сургуульд элсэж чадсан бол хамгийн түрүүнд сонгосон сургуульдаа автоматаар элсэнэ.

Бүх дунд сургуулийн вэбсайт ба цахим системд 2024.5.15-нд нийтлэгдэнэ.

ДУНД СУРГУУЛЬД ЭЛСЭЖ ОРЖ ЧАДААГҮЙ ТУХАЙ

1-р шатанд дунд сургуульд орж чадаагүй өргөдөл гаргагчид **2-р шат болон дараагийн шатанд хүсэлтээ гаргаж болно**. Хэрэв өргөдөл гаргагч сургуулиа авч чадаагүй ба шалгалтын явцын талаар эргэлзэж байвал элсэлтийн хариу дүн нийтлэсэн өдрөөс хойш **ажлын 3 хоногийн дотор давж заалдан гомдол гаргаж болно**.

Хэрэв сургуулиуд 1-р шатны элсэлтийн шалгалтын дараа багтаамж дүүрээгүй нөхцөлд мэргэшлийн ангийн элсэлтийн хоёр дахь шатны (магадгүй дараах шат) шалгалт авах талаар зарлаж болно. Тухайн шатны шалгалтын шалгуурын нөхцөл тус бүр өөр өөр байж болно.

ХЭРЭГТЭЙ ВЭСБАЙТУУД:

🌐 <http://www.inkluzivniskola.cz/prijimaci-rizeni-na-ss>

🌐 <https://prijimacky.cermat.cz/>

📄 [Сургуулийн зөвлөгөө өгөх байгууламж \(ŠPZ\)](#)